




**НЬЮБАЛАНС АУДИТ**

Аудит баталгаажуулалт, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ

# АУДИТЫН ТАЙЛАН

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР  
БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТУХАЙД

Улаанбаатар хот 2019 он





# НЬЮБАЛАНС-АУДИТ ХХК

Хаяг: УБ хот БГ Дүүргийн 9-р хороо, 21-р байр Эрхэс-Одод төв 34 тоот  
Утас: 89110525, 99101901, 89110535, 95102505, Факс: (976)-70145542

2019 оны 01 сарын 29 өдөр

№: А/13

Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### "ХӨВСГӨЛ ХҮНС" ХК-ИЙН ЗАХИРАЛ Л.ЦЭРЭНЖАВ ТАНАА

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Хөвсгөл хүнс" ХКомпанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар "Хөвсгөл хүнс" ХКомпанийн 2018 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотологоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

"Ньюбаланс Аудит" ХХК  
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,  
9 хороо, Эрхэс одод төв, 34 тоот



**"Хөвсгөл Хүнс " ХК**

**АУДИТ ХИЙГДСЭН ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ**

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	
	өмнөх	тайланг
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10 445 949,82	19 471 132,52
Дансны авлага	210 980 136,20	152 351 469,60
Татвар, НДШ-ийн авлага	869 559,94	2 864 336,58
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	185 199 257,61	254 629 364,74
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>407 494 903,57</b>	<b>429 316 303,44</b>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	187 010 268,05	177 675 068,39
Биет бус хөрөнгө		
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бусад хөрөнгө		
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>187 010 268,05</b>	<b>177 675 068,39</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>594 505 171,62</b>	<b>606 991 371,83</b>
<b>Өр төлбөр</b>		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны өглөг	279 789 298,80	319 028 129,30
Цалингийн өглөг		
Татварын өр	35 893 873,56	3 890 392,52
НДШ-ийн өр		
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Бусад богино хугацаат өр төлбөр	6 100 988,00	100 988,00
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>321 784 160,36</b>	<b>323 019 509,82</b>
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Бусад урт хугацаат өр төлбөр		
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>321 784 160,36</b>	<b>323 019 509,82</b>
<i>Эзэмшигдийн өмч ба капитал</i>		
Өмч		
- төрийн		
- хувийн	26 382 000,00	26 382 000,00
Нэмж төлөгдсөн капитал	47 594 300,00	47 594 300,00
Эздийн өмчийн бусад хэсэг	120 000 000,00	120 000 000,00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		
Тайланг үе	78 744 711,26	89 995 562,01
Өмнөх үе		
<b>Эзэмшигдийн өмч ба капиталын дүн</b>	<b>193 976 300,00</b>	<b>283 971 862,01</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>515 760 460,36</b>	<b>606 991 371,83</b>

Аудитор:  Д.Гэрэлчулуун


**"Хөвсгөл Хүнс " ХК**

**АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	өмнөх	тайланг
<b>Борлуулалтын орлого</b>	806 886 626,89	915 697 425,29
Борлуулалтын өртөг	636 571 212,88	750 174 739,65
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>170 315 414,01</b>	<b>165 522 685,64</b>
Түрээсийн орлого		
Хүүний орлого		
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	162 586 600,95	153 021 740,39
Санхүүгийн зардал		
Бусад зардал	100 000,00	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>7 628 813,06</b>	<b>12 500 945,25</b>
Орлогын татварын зардал	762 881,30	1 250 094,50
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>6 865 931,76</b>	<b>11 250 850,75</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>Тайланг үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>6 865 931,76</b>	<b>11 250 850,75</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>6 865 931,76</b>	<b>11 250 850,75</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

Аудитор:



Д.Гэрэлчулуун

"Хөвсгөл Хүнс" ХК

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2017 оны 12-р сарын 31ний үлдэгдэл</b>	26 382 000,00		47 594 300,00			120 000 000,00	78 744 711,26	272 721 011,26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны заруулга								
<b>Залруулсан үлдэгдэл</b>								
Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)							11 250 850,75	11 250 850,75
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
<b>2018 оны 12-р сарын 31ний үлдэгдэл</b>	26 382 000,00		47 594 300,00			120 000 000,00	89 995 562,01	283 971 862,01

Аудитор:  Д.Гэрэлчулуун

"Хөвсгөл Хүнс" ХК

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	өмнөх	/Төгрөгөөр/ тайланг
<b>1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>		<b>1 084 157 643,70</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1 082 023 086,70	1 082 023 086,70
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар	2134557	2 134 557,00
Бусад мөнгөн орлого		
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>		<b>1 073 978 006,45</b>
Ажилчидад төлсөн	102 918 305,00	102 918 305,00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	30 524 475,00	30 524 475,00
Бараа материал худалдан авхад төлсөн	572 552 244,09	572 552 244,09
Ашиглалтын зардалд төлсөн	200 000,00	200 000,00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	362 813 427,82	362 813 427,82
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	4 969 554,54	4 969 554,54
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>10 179 637,25</b>
<b>2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>1 154 454,55</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1 154 454,55
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>дүн</b>		<b>(1 154 454,55)</b>
<b>3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Ханшийн зөрүүний олз		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>-</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн төлбөрт төлсөн		
Хувьцаа буцаан худалдан авхад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Ханшийн зөрүүний гарз		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>-</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>9 025 182,70</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10 445 949,82
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		19 471 132,52

Аудитор:  Д.Гэрэлчулуун



# НЬЮБАЛАНС-АУДИТ ХХК

Хаяг: УБ хот БГДүүргийн 9-р хороо, 21-р байр Эрхэс-Одод төв 34 тоот  
Утас: 89110525, 99101901, 89110535, 95102505, Факс: (976)-70145542

2019 оны 01 сарын 26 өдөр

№: 75

Улаанбаатар хот

## АУДИТЫН ГЭРЭЭТ АЖЛЫН ЗАХИДАЛ

### ХӨВСГӨЛ ХҮНС ХК ЗАХИРАЛ Л.ЦЭРЭНЖАВ ТАНАА

#### Аудитын зорилго болон хамрах хүрээ

Та бүхэн Хөвсгөл хүнс хувьцаат компаний 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийхийг биднээс хүссэн билээ. Бид энэхүү захидлаар уг гэрээт ажлыг хүлээн авснаа болон түүний талаарх өөрсдийн ойлголтыг баталгаажуулахдаа таатай байна. Бид аудитыг санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлтээ илэрхийлэх зорилгын үүднээс хийх болно.

#### Аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС), Монгол Улсын Аудитын тухай хууль болон Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан гарын авлага, холбогдох заавар журмын дагуу явуулна. Иймд аудитор нь санхүүгийн тайлангуудыг материаллаг буруу илэрхийлэгдээгүй гэсэн хангалттай хэмжээний зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлан дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажлууд багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэгдэж болох эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Мөн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлоготой, хийсэн чухал тооцооллын ул үндэслэлтэй байдлыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн толилуулгыг ерөнхийд нь үнэлдэг.

Аудитын уламжлалт хязгаарлалтууд, түүнчлэн дотоод хяналтын уламжлалт хязгаарлалтуудаас шалтгаалж, хэдийгээр аудитыг АОУС-ын дагуу зөв төлөвлөж, гүйцэтгэсэн ч гэсэн зарим материаллаг буруу илэрхийлэл илрэлгүй үлдэж ч болох зайлшгүй эрсдэл байдаг.

Эрсдэлийн үнэлгээг хийхдээ бид байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус, зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэхтэй холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Гэхдээ, санхүүгийн тайланд хийх аудитын явцад бид өөрсдийн ажигласан дотоод хяналтын аливаа томоохон дутагдлын талаар та бүхэнд бичгээр мэдэгдэх болно.

### Үйлчлүүлэгчийн хүлээх үүрэг, хариуцлага

Зохих нэмэлт тодруулга, тайлбар бүхий санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж танилцуулах нь удирдлагын үүрэг болно. Үүнд: Нягтлан бодох бүртгэл хөтлөх, дотоод хяналтыг зохион байгуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж хэрэглэх, хөрөнгийн хадгалалтын найдвартай байдлыг хангах зэрэг зүйлс багтдаг. Үйлчлүүлэгч нь дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой аудиторын бэлтгэж хүргүүлсэн “Шаардлагатай мэдээллийн жагсаалт”-д дурдсан материалууд болон бусад холбогдох бүх материалыг аудиторт бүрэн танилцуулах үүрэгтэй. Аудитын явцад аудиторын залруулах шаардлагатай гэж үзсэн материаллаг зөрчлийг аудиторын санал болгосны дагуу залруулах асуудлыг ул үндэслэлтэй судалж, шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

Мөн аудитын явцад компанийн удирдлагаас аудит хийхтэй холбоотой компанийн удирдлага, бүртгэл санхүү, үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга, аудитын төгсгөлд аудиторт танилцуулсан материалын хариуцлагын талаар баталгаа гаргаж өгөхийг хүсэх болно. Удирдлагын хариуцлагын талаарх баталгаа захидал нь аудиторт танилцуулаагүй үлдсэн материалын талаарх хариуцлагыг тодорхойлсон байдаг.

Бидний хийх аудитын ажлын нэг хэсэг болохын хувьд, аудиттай холбогдуулан удирдлага болон шаардлагатай тохиолдолд засаглах эрх бүхий этгээдийн зүгээс бидэнд өгсөн тайлбар мэдүүлгийг бичгээр баталгаажуулж өгөхийг хүсэх болно.

Аудитын явцад танай ажилтнууд бидэнтэй хамтран ажиллана гэдэгт бид найдаж байна.

Бидний тайлангийн хэлбэр болон агуулгад ажлын үр дүнгээс хамаарч нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарч болно.

Энэ бүхэн та бидний хүлээх үүрэг, хариуцлага болон санхүүгийн тайланд бидний хийх аудитыг зохион байгуулах талаарх та бүхний ойлголттой нийцэж байгаагийн илэрхийлэл болгож энэхүү захидлын хавсралт хувь дээр гарын үсэг зурж, бидэнд ирүүлнэ үү.

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК

Гүйцэтгэх захирал  /Б.Лхагвадорж/

Огноо .....

